



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/ЗС 4

Номгон

Иргэн Т.Хайсандай, Ч.Ванчигмаа нарт  
газар эзэмшүүлэх тухай


Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 08 дугаар сарын 26-ны 81 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Баянхонгор сумын Номгон 1 дүгээр баг, Лувсанданзанжанцангийн өргөн чөлөө-5, 5016 тоот хаягт байрлах 12-р байрны өргөтгөлийн зориулалтаар иргэн Т.Хайсандайгийн (ВЮ45021077) эзэмшихийг хүссэн 63 м2 газрыг, Номгон 1 дүгээр баг, Лувсанданзанжанцангийн өргөн чөлөө-5, 508и тоот хаягт байрлах 17-р байрны өргөтгөлд үйлчилгээ явуулдаг иргэн Ч.Ванчигмаад (ВЮ73042562) үл хөдлөх хөрөнгийн доорхи 64 м2 газрыг тус тус дуудлага худалдааны анхны үнийг 2 дахин өсгөн нөхөн төлбөр төлүүлж, худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалтаар эзэмшүүлсүгэй.

2.Эзэмшил газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл), эзэмшил газарт Улсын бүртгэлийн "Э" дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг газар эзэмшигч иргэдэд үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

621010789